



# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

### АГУУЛГА

---

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

Газрын дарга: С.Энхзаяа  
Утас: 261663  
Цахим хаяг: [enkzayas@audit.gov.mn](mailto:enkzayas@audit.gov.mn)

Аудитын менежер: Л.Одгэрэл  
Утас: 260512  
Цахим хаяг: [odgerell@audit.gov.mn](mailto:odgerell@audit.gov.mn)

Ахлах аудитор Ж.Батсайхан  
Утас: 261628  
Цахим хаяг: [batsaikhanj@audit.gov.mn](mailto:batsaikhanj@audit.gov.mn)

Үндэсний Аудитын Газар

Засгийн газрын IY байр  
Бага тойруу 6  
Улаанбаатар-46  
Монгол улс

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Оршил

Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ

Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан  
шийдлүүд

Залруулаагүй алдаа

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитын санал дүгнэлт

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 1:** Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудит хийсэн санхүүгийн тайлан

**Хавсралт 4:** Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн  
тайлан

## Оршил

Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг Эдийн засгийн хөгжлийн яамны удирдлагад танилцуулж байна.

Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанд төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг 4 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх хуулийн хугацаанд өмнөх шатанд хийсэн аудитын дүнг нэгтгэж, дүн шинжилгээ хийхээс гадна Эдийн засгийн хөгжлийн яамны аппаратын санхүүгийн зарим үйл ажиллагаанд түүвэр сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэв.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүүгийн дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Эдийн засгийн хөгжлийн сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар дараах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тайлант хугацаанд эдгээр асуудалд бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан байна. Үүнд:

- хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;
- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал;
- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хөгжлийн төлөвлөлт хийх, салбар хоорондын бодлогын уялдааг хангах асуудал;
- эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал;
- зээл, тусламжийн нэгдсэн бодлого;
- худалдааны бодлого, зохицуулалт;
- экспорт, импортын асуудал;
- гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл;
- эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдсэн бодлого, зохицуулалт;
- өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал
- чөлөөт бүсийн хөгжлийн асуудал;
- концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого.

Эдийн засгийн хөгжлийн яам дээрх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан байгууллагын хэмжээнд тайлант хугацаанд нийт 234 орон тоотой ажилласны дотор яамны аппарат 136 орон тоотой ажилласан байна.

Эдийн засгийн хөгжлийн яамны тайлант хугацаанд хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааны үр дүнг нэгтгэсэн ажлын тайланг аудитын нотлох зүйлд хадгалав.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүүгийн дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаархи тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, объект дээрх үе шат, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад мөрдсөн стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### **Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ**

Бид үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг аудитын горимын дагуу дахин хянасан.

Аудитын явцад Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний санхүүгийн дотоод хяналтыг үнэлэхэд үйл ажиллагаандаа холбогдох стандарт, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсөвт байгууллагад мөрдөх УСНББОУС-ийн бодлого, заавар, журмыг мөрдөж ажиллажээ.

Эдийн засгийн хөгжлийн яамны Хяналт-Шинжилгээ, Үнэлгээ, Дотоод Аудитын газар нь Бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ, аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гарган гүйцэтгэлийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

1. Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явцад үр дүнд суурилсан хяналт, үнэлгээ хийж, бодлогын хэрэгжилтийг үр ашигтай зохион байгуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн дүгнэлт, зөвлөмж гаргах;
2. Үндэсний хэмжээний хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх, хяналт, үнэлгээний үр дүнг бодлогын төлөвлөлт болон хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлоготой уялдуулах санал, зөвлөмж гаргах;
3. Яамны төлөвлөлтийн баримт бичгүүдийн хэрэгжилттэй холбоотой дотоод үйл ажиллагаанд хяналт тавьж удирдлагыг мэдээллээр хангах, төсвийн тухай хуулийн дагуу санхүүгийн дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
4. Яамны шугамаар хийгдсэн бодлогын судалгаа, шинжилгээ, үнэлгээний талаарх мэдээллээр цахим мэдээллийн сан бүрдүүлж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;
5. Монгол Улсад үр дүнд суурилсан хяналт, үнэлгээний аргыг нэвтрүүлэх чиглэлээр ЗГХЭГ, яамдууд, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж ахиц дэвшил гаргахад тэргүүлэх үүрэгтэйгээр оролцох.

Тус газар Эдийн засгийн хөгжлийн яамны 5 газрын нийт 93 ажил, үйл ажиллагаанд дотоод хяналт, эрсдэлийн судалгааг хийж, тэдгээрээс өндөр эрсдэлтэй 29, дунд эрсдэлтэй 27 ажил болон хөндлөнгийн аудитын мөрөөр хийх дотоод аудитыг тусган Яамны дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Дотоод аудитын 2013 оны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

1. Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний боловсруулалт, 2012 оны төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүжилт, зарцуулалтын явц байдалд хяналт, шинжилгээ, дотоод аудитыг хийж дараах санал зөвлөмжийг гарган хүргүүлсэн байна. Үүнд:

- Чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг шинэчлэн батлуулах,
- Чойрын эдийн засгийн чөлөөт бүсийг татан буулгаж, логистикийн төв байгуулах, Алтанбулаг, Замын-Үүд, Цагааннуур чөлөөт бүсүүдийн Захирагчийн ажлын албадыг нэгдмэл тогтолцоонд оруулж, "Чөлөөт бүс" УҮГ болгон өөрчлөх ажлыг зохион байгуулах,
- Чөлөөт бүсүүдийн бүтээн байгуулалтын ажлыг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай концессын гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах,
- Хяналт шалгалтаар илэрсэн ашиглагдаагүй, бүртгэгдээгүй байгаа үндсэн хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах,

Эдийн засгийн хөгжлийн яам санхүү, аж ахуйн үйл ажиллагаа зэрэг төрийн нийтлэг үйлчилгээг гэрээний үндсэн дээр "Төрийн үйлчилгээ" УТҮГ-аар хийлгэж байна.

Тус газар зөвхөн яамны аппаратын санхүү, аж ахуйн үйл ажиллагааг батлагдсан төсвийн хүрээнд гэрээний дагуу эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд яамны удирдагууд Төсвийн тухай хуулийн 14.5-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь түүнд хамаарах төсвийн асуудлыг хариуцан гүйцэтгэх санхүүгийн нэгж, нягтлан бодогч, ажилтантай байна." гэсэн заалтыг үндэслэж, салбарын хэмжээний төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг нэгтгэж, хянах, тайлагнах, санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зэрэг чиг үүргийг 2014 оны 2 дугаар сард төсвийн багц хариуцсан мэргэжилтэн гэсэн орон бий болгож, албан ёсоор хариуцуулжээ.

Энэ нь цаг хугацааны хувьд сунжирсан ч төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг зохион байгуулах, салбарын хэмжээний санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өр, төлбөрийг өдөр тутмын хяналт удирдлагаар хангах боломж нөхцөл бүрдсэн байна.

### **Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг энэ тайланд хураангуйлан тэмдэглэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

### Өмнөх түвшинд хийсэн аудитын дүнгийн талаар

Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 5 нэгж байгууллага нэгтгэсэн бөгөөд тэдгээрийн 80 хувь буюу 4 байгууллагад хараат бус аудитын байгууллага гэрээний үндсэн дээр санхүүгийн аудит хийж дүгнэлт гаргасан байна.

/Сая төгрөгөөр/

№	Нэгжийн нэр	Дуусвар болгосон тайлан		Менежментийн захидал		Аудит санал дүгнэлтийн хэлбэр			Төлбөрийн акт		
		Асуудлын тоо	Дүн	Асуудлын тоо	Дүн	зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзах	Тоо	Дүн
1	"Цагаан нуур" ХЧБ	7	8.8	3	2	1					
2	"Замын үүд" ЭЗЧБ	9	7.18	9	7.18	1			1	0.54	
3	"Алтан булаг" ХЧБ	4	17.7	2	17.7	1					
4	"Чойр" ЭЗЧБ	5	8.83	2	2.83	1			1	1.035	
	Дүн	25	42.51	16	29.71	3	1	0			1,5

Аудитад хамрагдсан байгууллагын 75 хувь буюу 3 байгууллага зөрчилгүй, 25 хувь буюу 1 байгууллага хязгаарлалттай дүгнэлт авчээ.

Аудитаар нийт 1,5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, аудит хийсэн байгууллагад хариуцуулсан байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг дуусвар болгосон тайлан, менежментийн захидалд тусгасан байдлаар ангилан нэгтгэхэд дуусвар болгосон тайланд 25 асуудлаар 42,5 сая төгрөг, менежментийн захидалд 16 асуудлаар 29,7 сая төгрөгийн зөрчил дутагдлыг аудит хийлгэсэн байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулсан байна.

Тухайлбал "Цагаан нуур" худалдааны чөлөөт бүс Цагаан нуур тосгонд байрладаг конторын барилгыг бусдад түрээсэлж, 8,429.35 мянган төгрөгийн орлого, тухайн орлогоос зарцуулсан 8,403.35 мянган төгрөгийн зардлыг санхүүгийн тайландаа тусгаагүй байжээ. Нягтлан бүртгэл, тайлангаас гадуур эдгээр гүйлгээг

төрийн сангийн нэгдсэн тогтолцооноос гадуур зохих зөвшөөрөл шийдвэргүй арилжааны банкинд нээсэн харилцах дансаар дамжуулан гүйцэтгэж байсныг аудитын явцад заларуулж, уг дансыг хаалгасан байна.

Дээрх чөлөөт бүсийн 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харахад 29,3 сая төгрөг хэмнэн төсөвт буцаан төвлөрүүлсэн боловч төсвийн хөрөнгийн зарцуулалтыг зардлын ангилалаар задлан үзэхэд цэвэр, бохир усны зардлыг 575,0 мянган төгрөгөөр, төлбөр хураамжийг 960,2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг 472,4 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

"Чойр" эдийн засгийн чөлөөт бүсэд хийсэн аудитаар тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн шинжтэй 2,342.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан боловч хөрөнгийн данс бүртгэлд тусгалгүй тайлант хугацааны зардал болгож тайлагнасан байна. Үүнд: бараа материалаар бүртгэгдэх 255.0 мянган төгрөг, биет хөрөнгөөр бүртгэгдэх 250.0 мянган төгрөг, биет бус хөрөнгөөр бүртгэгдэх 1,837.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг зардлаар бүртгэсэн байна.

Мөн тайлант хугацаанд "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн "Acolous 3.0" санхүүгийн программыг 1,837.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь зах зээлийн үнээс 2.4 дахин илүү үнэтэй байна.

Тус чөлөөт бүсийн хөрөнгөнд бүртгэлтэй 2 автомашины нэг болох "Соната-6" маркийн суудлын автомашиныг Эдийн засгийн хөгжлийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга ашигладаг бөгөөд 2013 онд шатахууны зардалд батлагдсан 1,095.0 мянган төгрөгнөөс 1,035.5 мянган төгрөгийн шатахууныг тус газрын дарга авч ашигласан байна.

"Замын үүд" эдийн засгийн чөлөөт бүсэд хийсэн аудитаар дотоод томилолтын зардлаас завсрын аудитаар 2,333.02 мянган төгрөгийн баримтыг, жилийн эцсийн аудитаар 2,636.56 мянган төгрөгийн баримтыг тус тус сонгон авч шалгахад дараах зөрчлүүд илэрсэн байна.

Албан томилолтын хуудсыг галт тэрэгний билет дээрх зорчигчдын нэрстэй тулган шалгахад 819.0 мянган төгрөг бүхий 31 ширхэг галт тэрэгний билетнээс нэрс зөрүүтэй 354.9 мянган төгрөгийн 14 ширхэг билетийг баримт болгон бүрдүүлсэн ба 47.6 мянган төгрөгийн замын зардал огт баримтгүй байна.

Томилолтын зам хоног, байрны нийт 1,216.4 мянган төгрөгийн зардлыг нотлох анхан шатны баримтгүй байна. Мөнгөн урьдчилгааны тайлангаар нийт 250.0 мянган төгрөгөөр автамашин түрээсэлснээр тайлагнасан боловч холбогдох гэрээ, түрээсийн мөнгийг хүлээн авсан нотлох анхан шатны баримт байхгүй байна.

Томилолтын удирдамжинд ямар үүрэг даалгавартай, ямар албан тушаалтан томилолтоор явж байгаа нь тодорхойгүй, томилолтын буудал болон хоолны баримтанд 720.0 мянган төгрөгийн скайнердсэн баримт хавсаргасан бөгөөд томилолтоор ажиллуулах тухай Захирагчийн 2013 оны 12 сарын 19-ны өдрийн №А/43 дугаар захирамжид Эрээн хот орох 2 хүний 2 хоногийн 1,081.6 мянган төгрөгийн гадаад томилолтын зардалыг тусгасан бөгөөд хилээр нэвтэрсэн гадаад паспортын огноог тулгахад Н.Шаравдорж 2013.11.22-11.24 нд Эрээн хотод байсан бол Х.Баярхүү 2013.12.12-12.26-нд Эрээн хотод байсан байна.

Н.Шаравдорж нь тухайн томилолтын хугацаанд БНХАУ-ын Эрээн хотод томилолтоор ажилласан нь тухайн баримтаар нотлогдохгүй байна. Томилолтын илтгэх хуудсыг томилолтоор ажиллаагүй ажилтан бичжээ.

Энэ шатанд хийсэн санхүүгийн аудитаар үйлчлүүлэгч байгууллагын 2013 оны санхүүгийн тайланд 7 асуудлаар 700,6 сая төгрөгийн залруулга хийжээ.

## **Төсвийн ерөнхийлөн захирагчийн шатанд хийсэн аудитын дүнгийн талаар**

### **Асуудал 1: Зардал / Үндсэн хөрөнгийн талаар**

Эдийн засгийн хөгжлийн яам 2013 онд төвлөрсөн арга хэмжээ, төлбөр хураамж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлаас нийт 62,78 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зохих зөвшөөрөл шийдвэргүйгээр бэлтгэсэн байна.

Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.1.3, 14.2.4, Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 1.8, 2.1, 2.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Өмнөх жилд энэ төрлийн зөрчил гарч байсан бөгөөд энэ талаар аудитын тайланд тэмдэглэж, цаашид зөрчил гаргахгүй байх талаар зөвлөмж боловсруулахаар шийдвэрлэв.

### **Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар**

Тус яамны 2012 онд батлагдсан төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдан авсан 145.54 сая төгрөгийн үнэтэй “Mercedes Benz S350” маркийн суудлын автомашин 2013 оны 4 дүгээр сарын сард ХБНГУ-аас улсын хилээр орж ирсэн байна. Энэ автомашиныг нягтлан бодох бүртгэлд “компьютер техник хэрэгсэл” дансанд “машин тоног төхөөрөмж” нэрээр 140,2 сая төгрөгөөр бүртгэж, 2012, 2013 оны санхүүгийн тайланд тусгажээ.

Харин Төрийн өмчийн хорооноос энэ автомашиныг худалдан авах зөвшөөрлийг 2012 оны 12 дугаар сард өгсөн байна.

Иймд дээрх автомашиныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4, 8.5–д заасны дагуу холбогдох баримт материалыг үндэслэж, автотээврийн хэрэгслийн дансанд шилжүүлэн бүргэж, залруулга хийхийг зөвлөмж болгов.

### **Асуудал 3: Зардал, мөнгөн хөрөнгийн талаар**

Эдийн засгийн хөгжлийн яамны 2013 оны урсгал зардлын төсөвт эрдэм шинжилгээний ажлын зардалд 3,315.6 сая төгрөг батлагдсан байна. Энэ зардлын эх үүсвэрээс гэрээний үндсэн дээр хийгдэх 7 судалгаа, шинжилгээний ажлын хөлс 239,45 сая төгрөгийг зохих зөвшөөрөлгүй арилжааны банкинд түр байршуулсан байна. Харин тус яамны 2013 оны санхүүгийн тайланд судалгаа, шинжилгээний ажлын хөлсөнд урьдчилж шилжүүлсэн дээрх мөнгийг судалгааны ажлын тайлан гараагүй, гэрээ дүгнэж, баталгаажуулаагүй байхад тайлант хугацааны зардалд тусгаж, тайлагнасан байна.

Иймд арилжааны банкин дахь харилцах дансыг хаалгаж, ажлын хөлсний урьдчилгаа 239,45 сая төгрөгийг мөнгөн хөрөнгө хэлбэрээр бүртгэж, судалгаа шинжилгээний ажлын зардлыг энэ хэмжээгээр бууруулах бичилт хийж, санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийлээ.

#### **Асуудал 4: Худалдан авах ажиллагааны талаар**

Төлөвлөсөн ёсоор салбарын хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг Сангийн яаманд хүргүүлсэн тайлантай тулган баталгаажуулж, худалдан авах ажиллагааг иж бүрэн, бодитой төлөвлөж, тайлагнасан эсэхийг тулган баталгаажуулав.

Эдийн засгийн хөгжлийн яам худалдан авах төлөвлөгөө, тайланг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад үндэслэн гаргасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн төлөвлөж, тайлагнаагүйг харуулж байна.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу төсвийн хөрөнгө оруулалт, урсгал төсөв, өөрийн хөрөнгө, зээл, тусламжийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр, иж бүрэн төлөвлөж, тайлагнах ёстой.

Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын түвшин тус бүрийг шат шатанд нь нэгтгэх замаар салбарын хэмжээний худалдан авах ажиллагааг нэгтгэж, удирдах боломж бий болгох удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **Асуудал 5: Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн талаар**

Чингис бонд болон хөрөнгө оруулалтын зорилгоор Засгийн газраас гаргасан үнэт цаасны хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, тэдгээрийн нэгдсэн удирдлага, хяналтын үйл ажиллагаа Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг бөгөөд үйл ажиллагааг нь зохицуулах түр журмыг Эдийн засгийн хөгжлийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан байна.

Дээрх эх үүсвэрээр санхүүжиж, үйл ажиллагаа явуулдаг төслийн нэгжийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэр холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, тэдгээр төслийн нэгжийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, хөрөнгө, өр төлбөрийг холбогдох стандарт, хууль тогтоомжид нийцүүлэн тайлагнасан эсэх, тэдгээрийг төсвийн бүрэлдэхүүнд үнэн зөв, иж бүрэн тайлагнаж байгаа эсэх асуудлыг аудитын явцад тогтоохоор төлөвлөсөн боловч бидний шаардсан төслийн жагсаалт болон холбогдох мэдээ, тайлан, бусад баримт материал гаргаж өгөөгүй тул цаг хугацааны хувьд энэ аудитын явцад эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй болж, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад асуудлыг тодруулахаар яамны Төрийн нарийн бичгийн даргатай харилцан тохиролцож хойшлуулав.



Энэ нөхцөл байдлыг яамны удирдлагууд тайлбарлахдаа “Чингис бонд болон хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасны хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжиж, үйл ажиллагаа явуулдаг төслийн нэгжийн удирдлага, зохион байгуулалт, тэдгээр төслийн нэгжийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, хөрөнгө, өр төлбөрийг төсвийн бүрэлдэхүүнд оруулах эсэх асуудал шийдэгдээгүй тул төсвийн багцын санхүүгийн тайланд эдгээр асуудал хамааралгүй” гэсэн тайлбар гаргасан болно.

### **Залруулаагүй алдаа**

Аудитын олон улсын стандартын дагуу аудитын явцад илрүүлсэн санхүүгийн тайланд залруулаагүй материаллаг биш аливаа алдаа, зөрчлийг тухайн байгууллагын удирдлагын анхааралд хандуулах шаардлагатай байдаг.

Дээрх шаардлагын дагуу энэ удаагийн аудитаар илэрсэн зарим алдаа зөрчлийг арилгах, цаашид дахин давтан гаргахгүй байхыг аудитын явцад үүрэг болгож, асуудлын бүртгэлд 4 асуудал тусгасанаас тус яамны удирдлагад 3 асуудлын мөрөөр холбогдох арга хэмжээ авах зөвлөмж өгсөн болно. Зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитын явцад материаллаг байдлын түвшинг төсвийн гүйцэтгэлийн 2 хувиар тооцож, 302,0 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийх явцад 42,5 сая, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад 203,0 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрч материаллаг байдлын түвшинтэй харьцуулав.

Залруулаагүй алдаа, зөрчил материаллаг түвшинд хүрээгүй тул бидний дүгнэлтийг хязгаарлах, өөрчлөх үндэслэл болоогүй.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Үндэсний аудитын газар Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2012 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар орон нутагт 20 асуудлаар зөвлөмж боловсруулж хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Харин Сайдын багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн төлөвлөлтийг бодитой хийх, худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах зэрэг 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг үйлчлүүлэгч байгууллагаар гаргуулж, баталгаажуулсан болно.

### **Аудитын санал дүгнэлт**

Бид Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эдгээр стандартад зааснаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор салбар нэгжид хийсэн

аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэх, аудит хийгдээгүй зарим нэгжийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа, түүний дотор касс, харилцахын болон бусад анхан шатны баримтыг дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл, тайлангийн зохих үзүүлэлтүүдтэй тулган шалгав.

Бидний дүгнэлтээр Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын бэлтгэсэн 2013 оны санхүүгийн тайлангууд нь бүгд материаллаг зүйлсийн хувьд 2013 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол улсад мөрдөж байгаа стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөвөөр илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН  
САЙД Н.БАТБАЯР ТАНАА

2014.04.25 № 672  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу Эдийн засгийн хөгжлийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Эдийн засгийн хөгжлийн яамны удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Эдийн засгийн хөгжлийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

  
А.ЗАНГАД



## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### Менежментийн захидал

#### **Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:**

**Асуудал 1** Зардал, үндсэн хөрөнгийн талаар

**Асуудал 2** Үндсэн хөрөнгийн талаар

**Асуудал 3** Худалдан авах ажиллагааны талаар

**Асуудал 4** Хариуцлага тооцох тухай

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа, түүнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага юм.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн санхүүгийн аудитаар үйлчлүүлэгч байгууллагад хандаж, 16 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Эдийн засгийн хөгжлийн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн ажилтнууд болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.**

**Ажиглалт**

Эдийн засгийн хөгжлийн яам 2013 онд төвлөрсөн арга хэмжээ, төлбөр хураамж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлаас нийт 62,78 сая төгрөгийн үндсэн хөрөнгө зохих зөвшөөрөл шийдвэргүйгээр бэлтгэж тайлагнасан байна.

Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.1.3, 14.2.4, Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 1.8, 2.1, 2.5 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай үнэн зөв байх, илчлэл ба толилуулга батламж мэдэгдэл зөрчигдөх

**Зөвлөмж**

Төсвийн хөрөнгөөр бэлтгэх үндсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг системийн хэмжээнд бодитой тооцож, төсвийн төлөвлөгөөнд зохих ангилалаар тусган хэрэгжүүлж байх.

Өмнөх жилд энэ төрлийн зөрчил гарч байсан бөгөөд энэ талаар аудитын тайланд дахин тэмдэглэж, цаашид зөрчил гаргахгүй байхыг анхааруулав.

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны жилийн эцсээр тооцож, хариу ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

**Ажиглалт**

Тус яамны 2012 онд батлагдсан төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр худалдан авсан 145.54 сая төгрөгийн үнэтэй “Mercedes Benz S350” маркийн суудлын автомашин 2013 оны 4 дүгээр сарын сард ХБНГУ-аас улсын хилээр орж ирсэн байна. Энэ автомашиныг нягтлан бодох бүртгэлд “компьютер техник хэрэгсэл” дансанд “машин тоног төхөөрөмж” нэрээр 140,2 сая төгрөгөөр бүртгэж, 2012, 2013 оны санхүүгийн тайланд тусгажээ.

Харин Төрийн өмчийн хорооноос энэ автомашиныг худалдан авах зөвшөөрлийг 2012 оны 12 дугаар сард өгсөн байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай илчлэл ба толилуулга, үнэлгээ, тохиолдсон байх батламж мэдэгдэл зөрчигдөх

Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг тухай бүр хангаж ажиллахгүй зөрчил дутагдал гаргах

**Зөвлөмж**

Ажил гүйлгээг хуулийн хүчин төгөлдөр, иж бүрэн анхан шатны баримт материалд тулгуурлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.4-д заасан дарааллаар бүртгэж байхаас гадна мөн хуулийн гарсан алдаа зөрчлийг 8.5 заасны дагуу холбогдох баримт материалыг үндэслэж, автотээврийн хэрэгслийн дансанд шилжүүлэн бүргэж, залруулга хийх

Зөвлөмжийг 2014 оны эхний хагас жилд багтаан хэрэгжүүлж, биелэлтийг Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

**Ажиглалт**

Эдийн засгийн хөгжлийн яам худалдан авах төлөвлөгөө, тайланг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад үндэслэн гаргасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн төлөвлөж, тайлагнаагүйг харуулж байна.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсөв, өөрийн хөрөнгө, зээл, тусламжийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр, иж бүрэн төлөвлөж, тайлагнах ёстой.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланг толилуулахдаа гаргадаг бодит байдлын тухай үнэн зөв байх, тохиолдсон байх Хэмжилт ба толилуулгын талаар батламж мэдэгдэлүүд зөрчигдөх эрсдэлтэй байна.

Хууль, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг тухай бүр хангаж ажиллахгүй зөрчил дутагдал гаргах

**Зөвлөмж**

Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын түвшин тус бүрийг шат шатанд нь нэгтгэх замаар салбарын хэмжээний худалдан авах ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр нь нэгтгэж, удирдах тогтолцоо бий болгох удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах

Зөвлөмжийн биелэлтийг 2014 онд багтааж Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.



**Ажиглалт**

**Зөвлөмж**

Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 5 нэгж байгууллага нэгтгэсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас 2014 онд хийсэн санхүүгийн аудитын аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах.

